



ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ
ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ ТӨРИЙН
ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2023 оны 07 сарын 31 өдөр

Дугаар 19

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалт, “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн дүрэм”-ийн 9 дүгээр зүйлийн 9.3.15 дахь заалт, Эрчим хүчний сайдын “Удирдамж өгөх тухай” 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн а/2547 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн “Төлбөртэй ажил, үйлчилгээ гүйцэтгэх журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Шинэчлэн батлагдсан журмыг 2023 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.


3.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 10 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



З.МӨНХ-ОРГИЛ

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 07
дугаар сарын 31-ны өдрийн 19 дугаар
тогтоолын хавсралт



**“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн
төлбөртэй ажил, үйлчилгээ гүйцэтгэх журам**

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь компанийн үндсэн үйл ажиллагаанд саад учруулахгүйгээр дотоод нөөц боломжоо ашиглан тус компанид олгосон “Ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл”-ийн хүрээнд багтсан ажил, үйлчилгээг хуулийн этгээд, иргэдийн эзэмшлийн цахилгаан тоног төхөөрөмжид Эрчим хүчний зохицуулах хороо, компанийн Гүйцэтгэх захирлын тушаалаар баталсан ажил, үйлчилгээний жишиг ажлын хөлсийг мөрдөн төлбөртэй ажил, үйлчилгээ явуулан ашиг хуримтлалыг нэмэгдүүлж, улмаар ажилтнуудыг урамшуулах, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.
- 1.2. Төлбөртэй ажил, үйлчилгээний нэр төрөл, үйлчилгээний жишиг ажлын хөлсийг гүйцэтгэх захирлын тушаалаар батална.
- 1.3. Төлбөртэй ажил, үйлчилгээг холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, норм нормативын шаардлагад нийцүүлэн гүйцэтгэнэ.

Хоёр. Нэр томьёоны тодорхойлолт

- 2.1. “Ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл” гэж компанийн үндсэн үйл ажиллагаанаас гадна хуулийн этгээд, иргэдийн 0.4-220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын тоноглолыг шинээр болон хэсэгчлэн угсрах, засварлах, туршилт тохируулга, үйлчилгээ хийх эрхийг тус компанид эрх бүхий байгууллагаас олгосон албан ёсны бичгэн шийдвэрийг хэлнэ (цаашид тусгай зөвшөөрөл гэх).
- 2.2. “Төлбөртэй ажил” гэж тусгай зөвшөөрлийн хүрээнд багтсан, хуулийн этгээд, иргэдтэй харилцан тохиролцож, гэрээ байгуулан төсөвт заасан өртгөөр хийж гүйцэтгэх ажил болон гадны байгууллагын өмчлөлийн дэд станцад 24 цагийн шуурхай ажиллагаа явуулахыг хэлнэ.
- 2.3. “Төлбөртэй үйлчилгээ” гэж тусгай зөвшөөрлийн хүрээнд багтсан хуулийн этгээд, иргэдийн цахилгаан тоног төхөөрөмжийн техникийн байдалд үзлэг хийж, гэмтэл илрүүлэн засах, ашиглалт, аюулгүй ажиллагааны заавар боловсруулах, ажиллагааны горимын тооцоо ба реле хамгаалалт, автоматикийн тавилын тооцоо хийж, шалгаж тохируулах, хэмжилт, туршилт хийх, хэмжүүр, хэмжих хэрэгслийн ажиллагааг шалгаж баталгаажуулах, мэргэжлийн сургалт явуулах, зөвлөгөө өгөх, гадны байгууллагын өмчлөлийн тоноглолын талбайн төлбөр, ашиглалтын үеийн хадгалалт хамгаалалт, сэлгэн залгалт хийхийг гэрээгээр зохицуулж гүйцэтгэх, цахилгаан эрчим хүчний импортын үйлчилгээ үзүүлэх, зураг төсөв хийх болон хяналт тавих, полихпорт бифенил (ПХБ)-ээр бохирдсон цахилгаан тоноглолыг цэвэрлэх зэрэг ажлуудыг Гүйцэтгэх захирлын тушаалаар баталсан жишиг ажлын хөлсийг үндэслэн хийх үйлчилгээг хэлнэ.

Гурав. Төлбөртэй ажил гүйцэтгэх

- 3.1. Төлбөртэй ажлыг хуулийн этгээд, иргэдийн албан хүсэлтийг үндэслэн компанийн Гүйцэтгэх захирал болон салбарын даргын шийдвэрээр гүйцэтгэнэ.

3.2. Төлбөртэй ажлыг зохих дүрэм журам, стандарт, техникийн нөхцлийн дагуу хийгдсэн эрх бүхий байгууллагаар хянуулж баталгаажсан зураг, төсвөөр хийж гүйцэтгэнэ.

3.3. 20 сая төгрөг хүртэлх төлбөртэй ажлын гэрээг салбарын дарга шууд, 20 сая - 80 сая хүртэлх төлбөртэй ажлыг гүйцэтгэхэд салбарын дарга компанийн Гүйцэтгэх захирлаас зөвшөөрөл авсны үндсэн дээр гэрээ байгуулж, салбарын даргын тушаалаар байгуулсан ажлын хэсэг, салбарын ерөнхий инженерийн хяналтын дор хийж гүйцэтгэнэ.

3.4. Энэхүү журмын 3.3 дахь хэсэгт заасан мөнгөн дүнгээс дээш хэмжээний төлбөртэй ажлыг Гүйцэтгэх захирал гэрээ байгуулан, Гүйцэтгэх захирлын тушаалаар томилсон ажлын хэсэг, компанийн ерөнхий инженерийн хяналтын дор хийж гүйцэтгэнэ.

Дөрөв. Төлбөртэй үйлчилгээ гүйцэтгэх

4.1. Төлбөртэй үйлчилгээг хуулийн этгээд, иргэдийн албан хүсэлтийг үндэслэн компанийн Гүйцэтгэх захирал болон салбарын даргын зөвшөөрсөн шийдвэрээр гүйцэтгэнэ.

4.2. Төлбөртэй үйлчилгээг техникийн батлагдсан норм, дүрмийг баримтлан гүйцэтгүүлнэ.

4.3. Төлбөртэй үйлчилгээ гүйцэтгэхдээ тухайн салбарын үндсэн үйл ажиллагаанд саад учруулахгүйгээр зохион байгуулах ба энэхүү журмын 3.1, 3.2, 3.3, 3.4 дэх заалтыг тус тус баримтална.

4.4. Захиалагч байгууллагын төлбөрийн баримтыг үндэслэн наряд бичих, ЦДАШ, дэд станцын хамгаалалтын зурваст хяналт тавих, тодруулга хийх зэрэг ажлыг салбарын даргын шийдвэрээр салбарын ерөнхий инженерийн хяналтын дор холбогдох техникийн албадууд гэрээ байгуулахгүйгээр гүйцэтгэж болно.

4.5. Нарядаар гүйцэтгэх ажилд тухайн ажлыг хийх мэдлэг, чадвар бүхий ажлын удирдагч, ажил гүйцэтгэгч, бригадын бүрэлдэхүүнийг ажил гүйцэтгэгч томилж, ажлыг аюулгүй гүйцэтгүүлэхэд шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээг захиалагч байгууллага хариуцна.

Тав.Төлбөртэй ажил, үйлчилгээний орлогын төвлөрүүлэлт, зарцуулалт

5.1. Төлбөртэй ажил, үйлчилгээний орлогыг компанийн "Салбарын санхүүжилтийн журам"-д заасны дагуу компанийн дансанд төвлөрүүлнэ.

5.2. Үндсэн бус үйл ажиллагааны дансанд хуримтлагдсан эх үүсвэр (ашиг)-ийг хэрхэн зарцуулахыг гүйцэтгэх захирлын зөвлөл шийдвэрлэнэ.

5.3. Төлбөртэй ажил, үйлчилгээнд зарцуулах зардлыг уг ажлын төсвийг үндэслэн компанийн "Салбарын санхүүжилтийн журам"-д нийцүүлэн захиалгын дагуу олгоно.

5.4. Компани нь гэрээний дагуу хийж гүйцэтгэсэн төлбөртэй ажил, үйлчилгээний орлогоос төвлөрүүлсэн ашгаас дараах үйл ажиллагаанд зарцуулна. Үүнд:

5.4.1. Компанийн ажилтнуудад орон сууцны дэмжлэг үзүүлэх;

5.4.2. Шинэ инновац, технологийн ажил, ашиглалтын түвшинг сайжруулах, эрсдэлийг бууруулах, төлөвлөгөөнд тусгагдаагүй ажил гүйцэтгэх;

5.4.3. Үйлчилгээний тарифт тусгагдаагүй (БОШД) Хамтын гэрээнд заасан буцалтгүй тусламжийг олгох;

5.4.4. Төлбөртэй ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн ажилтнуудад энэхүү журмын 5.9 дахь заалтад заасан урамшууллыг олгох;

5.4.5. Ахмадын сан, эцэг эхийн зөвлөл, залуучуудын холбооны үйл ажиллагааг дэмжих;

5.4.6. Компанийн захиалгаар хийгдэх бүтээн байгуулалтад (нийтийн зориулалттай байр, амины болон төвлөрсөн дулаан хангамж бүхий орон сууц, зуслангийн хотхон зэрэг)

5.4.7. Бусад;

5.5. Энэхүү журмын 4.4 дэх заалтад заасан гэрээт бус төлбөртэй ажлаас олсон ашгийг улирал тутам компанийн дансанд нэгтгэн төвлөрүүлж, дараах үйл ажиллагаанд зарцуулж болно. Үүнд:

5.5.1. Техник технологийн хөгжүүлэлт;

5.5.2. Хүний нөөцийн сургалт;

5.5.3. Машин механизмын засвар үйлчилгээ;

5.5.4. Тухайн ажлыг гүйцэтгэсэн хэлтэс, салбаруудад нэн шаардлагатай асуудлыг нь шийдвэрлэх;

5.6. Салбар нь гэрээний дагуу хийж гүйцэтгэсэн төлбөртэй ажил, үйлчилгээнээс төвлөрүүлсэн ашгаас дараах үйл ажиллагаанд зарцуулж болно. Үүнд:

5.6.1. Төлөвлөгөөнд тусгагдаагүй, ашиглалтын түвшинг сайжруулах, эрсдэлийг бууруулах зайлшгүй шаардлагатай ажлуудыг хийж гүйцэтгэх;

5.6.2. Төлбөртэй ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн ажилтнуудад энэхүү журмын

5.9 дахь заалтад заасан урамшууллыг олгох;

5.7. Төлбөрт ажил, үйлчилгээний орлогоос бодит зарцуулалтыг хасаж, зарцуулагдаагүй үлдсэн санхүүгийн эх үүсвэр (ашиг)-ийн 30 хүртэл хувийг Гүйцэтгэх захирлын шийдвэрээр тухайн ажил гүйцэтгэсэн салбарт олгож болно.

5.8. Гүйцэтгэх захирлын шийдвэрээр хуваарилагдсан энэхүү журмын 5.7 дахь заалтад заасан эх үүсвэрийг салбарын даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн захиран зарцуулна.

5.9. Гэрээний дагуу төлбөртэй ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн ажилтнуудад ажлын хэсгийн даргын тодорхойлолтыг үндэслэн энэхүү журмын 5.7 дахь заалтад заасан хувь хэмжээний 50 хүртэл хувийг Гүйцэтгэх захирал эсхүл салбарын даргын тушаалаар олгож болно.

Зургаа. Төлбөртэй ажил, үйлчилгээг зохион байгуулахад хориглох зүйлүүд

6.1. Төлбөртэй ажил, үйлчилгээг гүйцэтгэхэд Гүйцэтгэх захирлын тушаалаар баталсан жишиг ажлын хөлсийг дур мэдэн өөрчлөхийг хориглоно.

6.2. Төлбөртэй ажил, үйлчилгээг компанийн цахилгаан эрчим хүч дамжуулах үндсэн үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр урсгал болон их засвар, ТЗБАХ-ний ажилтай давхцуулан гүйцэтгэхийг хориглоно.

6.3. Төлбөртэй ажил, үйлчилгээг гүйцэтгэхэд компанийн тоног төхөөрөмж, хэмжилт туршилт, реле хамгаалалтын багаж, хэмжих хэрэгсэл, тусгай зориулалтын машин механизмд гэмтэл учруулах (даац хэтрүүлэх, зориулалтын бусаар ашиглах зэрэг) бол ажил, үйлчилгээ явуулахыг хориглоно.

6.4. Төлбөртэй ажил, үйлчилгээ гүйцэтгэх үед хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулах нөхцөл байдал бий болсон тохиолдолд ажлыг нэн даруй зогсоож, эрсдэлт нөхцөл байдлыг арилтал тухайн ажлыг гүйцэтгэхийг хориглоно.

6.5. Төлбөртэй ажил, үйлчилгээг гүйцэтгүүлэхэд ажилтны тухайн сард ажиллавал зохих ажлын цагийн 50 хувиас хэтрүүлэн ажиллуулахыг хориглоно.

Долоо. Төлбөртэй ажил, үйлчилгээ гүйцэтгэх үеийн
хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа

7.1. Төлбөртэй ажил, үйлчилгээ гүйцэтгэх үед аюулгүй ажиллагааны хариуцагч нарыг тушаалаар томилж, тэдгээр нь ажлыг аюулгүй гүйцэтгэхэд шаардлагатай зохион байгуулалтын болон техникийн арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хариуцаж ажиллана.

Найм. Төлбөртэй ажил, үйлчилгээг гүйцэтгэх үеийн хяналт

- 8.1. Төлбөртэй ажил, үйлчилгээг норм стандарт, чанарын өндөр түвшин, технологийн шаардлагад нийцүүлэн гүйцэтгүүлэхэд тухайн ажлыг гүйцэтгэх алба, хэлтсийн дарга хяналт тавина.
- 8.2. Төлбөртэй ажил, үйлчилгээг гүйцэтгэсний дараа тухайн алба, хэлтсийн дарга техникийн хяналтын инженерийн хамт ашигласан машин механизм, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг шалган хүлээн авч, гэрээт ажлыг хаах, дүгнэх ажлыг зохион байгуулна.
- 8.3. Төлбөртэй ажил, үйлчилгээг гүйцэтгэх хугацаанд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, ААД, ТАД-ын мөрдөлтөд тухайн салбарын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн инженер (дотоод хяналтын ажилтан), техникийн хяналтын инженер хяналт тавина.
- 8.4. Компанийн дэд станц болон ЦДАШ-ын хамгаалалтын зурваст шугам сүлжээ, инженерийн байгууламж, авто зам барих, өргөтгөл шинэчлэл хийх зэрэг гадны байгууллагын гүйцэтгэх ажилд техникийн хэлтэс, албадууд байнгын хянагч томилно.
- 8.5. Төлбөртэй ажил, үйлчилгээг гүйцэтгэх үед Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн инженер (дотоод хяналтын ажилтан), техникийн хяналтын инженер нар аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч, явцын хяналт тавина.
- 8.6. Төлбөртэй ажил, үйлчилгээг гүйцэтгэхэд гарсан зардал, төсвийн дагуу гүйцэтгэж байгаа эсэхэд санхүүгийн холбогдох нэгжүүд тогтмол хяналт тавина.

Ес.Төлбөртэй ажил, үйлчилгээг удирдан гүйцэтгэх ажилтны эрх, үүрэг, хариуцлага

- 9.1. Төлбөртэй ажил, үйлчилгээг удирдан гүйцэтгэгч нь уг ажлыг хугацаанд нь, чанартай хийхэд шаардлагатай хүн хүч, сэлбэг материал, ажлын багаж хэрэгсэл, хувцас, машин механизмаар хангуулна.
- 9.2. Төлбөртэй ажил, үйлчилгээг удирдан гүйцэтгэгч нь цахилгаан байгууламжийн дүрэм, техник ашиглалтын дүрэм, цахилгаан тоноглол ашиглалтын заавар, цахилгаан тоноглолын угсралтын дүрэм, стандартыг мөрдлөг болгож, тухайн ажил үйлчилгээг хугацаанд нь чанартай хийж гүйцэтгүүлнэ.
- 9.3. Төлбөртэй ажил, үйлчилгээг удирдан гүйцэтгэгч нь тухайн ажил, үйлчилгээний чанар, ажлын багаж хэрэгсэл, хөдөлмөр хамгааллын хувцас, сэлбэг материал, машин механизмын ашиглалт, бүрэн бүтэн байдлыг хариуцна.
- 9.4. Ажилтан нь энэхүү журмын 3.1-т зааснаас бусад тохиолдолд компанийн машин техник, багаж төхөөрөмж, эд хөрөнгө, мэдээ мэдээлэл, баримт материалыг зөвшөөрөлгүйгээр ашиглан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад төлбөртэй, төлбөргүй ажил, үйлчилгээ эрхлэх, ажлын цагаар хөдөлмөрийн гэрээнд зааснаас өөр ажил үүрэг гүйцэтгэхийг хатуу хориглоно.
- 9.5. Энэхүү журмыг зөрчсөн ажилтанд холбогдох бусад хууль тогтоомж, компанийн "Хөдөлмөрийн дотоод журам"-ын дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Арав.Төлбөртэй ажил, үйлчилгээгээр гүйцэтгэсэн ажлыг хүлээж авах

- 10.1. Төлбөртэй ажил, үйлчилгээг дууссаны дараа ажлын удирдан гүйцэтгэгч холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын дагуу техникийн болон бусад шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлэн холбогдох техникийн удирдлагаар хянан баталгаажуулж, гэрээ дүгнэх ажлыг зохион байгуулна.
- 10.2. Захиалагч болон гүйцэтгэгч талын хамтран томилсон техникийн комисс уг ажил, үйлчилгээг зохих дүрэм журмын дагуу хүлээлцэнэ.